

Леви- Стросс. К. Структурная антропология. Глава IX. Колдун и его магия М., 1983

Орчуулсан магистр С.Соёлмаа

Бид Кенноны бүтээлүүд хэвлэгдэн гарснаас хойш дом шившлэг буюу илбэдэх үйлийн нөлөөнөөс үүдэлтэй үхлийн сэтгэц физиологийн механизмыг маш тодорхой төсөөлөх болсон билээ. Ийм тохиолдлууд дэлхийн бөмбөрцгийн аль ч газар орноо бүртгэгдсэн байдаг. Жишээ нь, илбэ домын хүчинд өөрийгөө автсан байна хэмээн үзэгч тэр этгээд басхүү овог бүлгийнхээ уламжлалт ойлголт ёсоор үйл нь ирж байгаа, гарцаагүй үхэх ёстой гэдэгтээ чанд хатуу итгэл үнэмшилтэй болдог. Энэхүү итгэл үнэмшлийг түүний төрөл төрөгсөд хийгээд ойр дотныхон нь ч ойлгон хүлээн авдаг. Тиймээс түүний харилцаа нь нийгмээс гэнэт тасарч эхэлдэг, тухайлбал муу ёр шүглэсэн этгээдээс бүгд зугтаж, түүнийг үхсэн лугаа харьцах төдийгүй, мөн эргэн тойрныхондоо гай зовлон тарихвий хэмээн үздэг. Ойр тойрны хүмүүс нь өөрсдийн бүх л үйл байдал, зан авир, мөн ямар ч хамаагүй шалтгаар азгүй этгээдэд үхлээс зайлсхийхгүй байхыг байнга тулгадаг, тэр этгээд ч зайлшгүй хувь заяандаа итгэдэг. Тэгээд мөнөөх этгээдэд зориулж ёс журмын үйл үйлдэх бөгөөд эдгээр ёслол үйл нь түүнийг үхлийн орноо хөтөчлөх учиртай бөлгөө. Муужирсан этгээдийг эхлээд гэр бүлийн болон нийгмийн харьцаанаас хүчээр хөндийрүүлдэг, тэгээд хувь хүн өөрийгөө бие хүн байдлаар ухаарч ухамсарладаг үйл ажиллагаа хийгээд ажил үүргээс нь салгадаг. Харин дараа нь тэрбээр нийгмийн аварга хүчтэй тулгарах бөгөөд амьдын ертөнцөөс хөөгдөх болж буй нь энэ. Ар араасаа угсран зогсоо зайгүй тулгарч буй зовлон, нийгмийн бүл хамтрагчаараа бүтээн бий болгосон харилцааны хэвшин дадсан тогтолцооноос хайр найргүй салгадаг явдал зэрэг нь ховсдсон этгээдэд айхавтар дарамт болдог. Эдгээр тогтолцоо түүний хувьд шууд нүүрээ буруулж, эрх үүрэг бүхий амьд хүн байсан түүнийг айдас түгшүүр, ёслол журам, хорио цээрийн объект-үхдэл болгон хувиргадаг¹⁰³. Ийнхүү нийгмийн үхлийг шууд залгаад биеийн үхэл эхэлдэг*.

Энэхүү адармаатай үзэгдэл бие махбодод (физиологт) яаж нөлөөлөөд байна вэ? Айдас нь почир (дүрсхийх) уур хилэнгийн нэгэн адил мэдрэлийн системийн дотоодод үлэмж эрчимтэй үйл ажиллагааг бий болгодог¹⁰⁴. Ийм үйл ажиллагаа ер нь ашиг тустай байдаг, учир нь үүнтэй зэрэгцэн бий болдог органик өөрчлөлтүүд нь хувь хүнийг шинэ нөхцөл байдалд дасан зохицох боломж олгодог, харин тухайн хүн ер бусын нөхцөл байдалд зөн совингийн шинжтэй, эсвэл бодож боловсруулсан хариу үйлдэлгүй, эсвэл хариу үзүүлэх чадваргүй гэж үзэж байгаа бол тэр хүний импатик мэдрэлийн системийн

¹⁰³ Энэ байр суринаас хандвал, “иргэний цаазын “ ёсыг (жишээ нь, XIX зуунд Орост байсан) хуучин үеийн үлдэгдэл(Леви-Строссынхоор, “псевдоархаизм”) гэж ойлгож болно.

* Иймэрхүү байдалд Австрали нутгийн нэгэн уугуул хүн 1956 оны 4 сард хүнд байдалтайгаар Дарвин хотын госпиталд хүргэгдсэн юм. Түүнийг хүчилтөрөгчтэй(сэхээний) өрөөнд байрлуулж, зондоор хооллуулсны үр дүнд тэрбээр аажмаар эдгэрсэн байна, учир нь тэрбээр “цагаан арьст хүний дом үйл хамгаас хүчтэй” гэдэгт итгэсэн байсан юм. (Morley A. Doctors saveman “sung to Death”. “Sunday times” (London), 22. IV.1956).

¹⁰⁴ “Хэрцгий байдал ба зайлсхийх” хариу үйлдлийн физиологийн шинж чанарын тухай Кенноны санаа нь Прибрамын бүтээлд цаашдын хөгжлийг олсон юм. Тэрбээр тархины тодорхой хэсгүүдийг, тухайлбал гипоталамусыг цахилгаанаар өдөөж, мөн амигдалыг ялгаснаар эдгээр хариу үйлдлийг олж харсан байдаг /Прибрам К. Языки мозга. М., 1975.с.227, 232/)

үйл ажиллагаа нь эрчимжээд уналтад ордог, хэдхэн цагийн дотор цусны эзлэхүүн багасаж, түүнийг дагаад даралт унах явдал ч гарч болно. Энэ нь цусны эргэлтийн эрхтнүүд бүр мөсөн хэмээ алдахад хүргэдэг. Ихэнх тохиолдолд хүчтэй айдсыг мэдэрсэн өвчтөнүүд хоол унднаас гардаг. Тэгснээр үйл явц муу талруугаа улам хурдсах болдог, тухайлбал, шингэний дутагдал нь мэдрэлийн системийн дотоод дахь (симпатик) үйл ажиллагааг өдөөж, цусны эзлэхүүний багасалт(агшилт) нь хялгасан судасны өсөн нэмэгдэж буй нэвчих чадварт хүндрэл болдог. Ийм таамагууд нь бөмбөгдөлтийн үед, дайны талбарт, эсвэл мэс заслын үйл ажиллагааны явцад тохиолдсон олон тооны судалгаагаар батлагддаг юм. Тодруулбал, задлан шинжилгээ хийхэд эрхтний ямар ч бэртэл гэмтэл байдаггүй аж. Зарим нэг шид домын үйлийн нөлөөлөх хүч нь эргэлзээ төрүүлдэггүй. Гэхдээ шид домын үйлийн нөлөөлөх хүч нь түүнд өөрт нь итгэх сүсэг бишрэлээс хамаардаг, тийм сүсэг бишрэлийг шаардах нь мэдээж хэрэг. Энэ сүсэг бишрэл нь бие биедээ нэмэлт болсон гурван хэлбэрээр илэрч байдаг аж. Юуны өмнө, илбэч бөөгийн өөрийнхөө барил тавилын хүч чадалд итгэх сүсэг итгэл байна, дараа нь, эмчлүүлж буй өвчтөн, илбэ жатганд нь өртөгч этгээд тэрхүү илбэч бөөгийнхөө ид шид хүч чадалд нь итгэх сүсэг бишрэл гэж байна, эцэст нь, хамтын(нийгмийн) итгэл ба түүний шаардлагууд гэж байна. Эдгээр шаарлага нь байнга үйлчилж нөлөөлөгч бүх ертөнцийн тогтолцлын оронтой төсөөтөй ямар нэгэн зүйлийг бий болгох бөгөөд үүний дотор илбэ шидийг үзүүлэгч бөөтөн болон түүний ид шидэнд ховсдуулагч этгээд нарын харилцаа (үйл ажиллагаа) хэрэгжиж байдаг¹⁰⁵.

Эдгээр сүсэг бишрэлийн аль нь ч Кенноны гомеостатик¹⁰⁶ хэмээн нэрлэсэн хямралууд болон мэдрэлийн системийн симпатик үйл ажиллагааны тухай тодорхой төсөөллийг бүтээж чадаггүй нь мэдээж юм. Илбэч этгээд өвчний шалтгааныг өвчтөний биеэс сорж авсан хэмээн баталж амандаа нууж байсан чулууг харуулахад тэр өөрөө үйлдэлд итгэдэг болов уу, хэрвээ итгэдэг бол яагаад? Ид шидийн нөхцөл байдал нь олны(нийтийн) санаа бодол болох consensus¹⁰⁷-аас шалтгаалдаг үзэгдэл мөн болох тул илбэ шид үзүүлсэн этгээдийг санал нэгтгэйгээр ялладаг, хэдий ийм ч энд зэм шийтгэлд өртсөн мөнөөх этгээд хэрхэн цагаатгагдаж, гэм зэмгүй болж таарч байна вэ? Онцгой хүч чадалтайг нь мэдрээд буй тэдгээр хүмүүст хандах харилцааны тухайд овог бүлэгт байх гэнэн итгэл эсвэл эргэлзэх байдлын хувь хэмжээ ямар байна вэ, энэ бүлэг хэнд давуу байдлыг олгож байна вэ, басхүү тэрбээр итгэж найдан, горьдлого тавьж давуу эрх олгон байсныхаа хариуг хэнээс шаарддаг вэ гэсэн асуулт эцэст нь гарч ирдэг. Сүүлчийн асуудлын судалгаанаас эхэлье.

* * *

Ийм нэг явдал 1938 оны 9 сард болсон юм. Бид хэдэн долоо хоногийн турш Төв Бразилийн залхуу хүргэм, халуун чийглэг ойд, Тапажозын булгийн ойролцоо

¹⁰⁵ Судлагдахуун нь социологийн шинжтэй гэхээсээ илүүтэйгээр психологийн шинжтэй энэхүү ажилд бололцоотой газарт нь шид домын арга барил болон илбэч шидтэний янз бүрийн хэв маяг хоорондын шашны социологи дахь чанд хатуу ялгаануудыг хэрэгсэхгүй байж болно хэмээн бид санаж байна. Үнэн хэрэгтээ хэд хэдэн нийгмийн хувьд, тухайлбал Леви-Строссын номын энэхүү бүлэгт судалж буй хойд америкчуудын бөөгийн соёлын хэв маягт хамаардаг нийгмүүдэд бөө нарын эсвэл илбэч нарын (ач буян үзүүлэгч “цагаан”, хараал жатга хийгч “хар” бөө) хоёр хэв маягийн чиг үүргийн эсрэгцэл чухал ач холбогдолтой. Кейтүүдийн тухай харьцуулах-49,61,62,с.281).

¹⁰⁷ Consensus – “зөвшил, зөвшилцөл гэсэн латин үг бөгөөд нийгмийн бүх гишүүд, тухайлбал, бүх мэргэжилтнүүд санал нэгтэй байгааг тэмдэглэсэн нэр томъёо юм.

Намбиквар Индианчуудын жижигхэн омогтой цуг байрлаж байлаа. Эндхийн уугуулууд(туземууд) жилийн ихэнх үед нь зэрлэг амуу тариа, үр жимсний эрэлд нүүдэллэн амьдрах ба сүүн тэжээлтэн жижиг амьтад, шавьж хорхой гээд өлсөж үхэхгүйн тулд юу ч хамаагүй барьж иддэг. Энд нүүдэллэн ирсэн гуч орчим хүн бороо, салхи, өдрийн аймшигт халуун, шөнийн хүйтнээс хамгаалах төдий мөчир гишүүгээр барьсан, нурах шахсан овоохойд бүлээрээ амьдарцгаадаг байв. Тэд бусад иймэрхүү омгийн олонхид байдагийн адилаар амьдралын үйл хэргийн хөтлөгч удирдагчтай бас илбэч бөөтөй байх аж. Бөөгийн өдөр тутмын эрхэлдэг ажил нь омгийн бусад эрчүүдийн ажлаас ер ялгарах зүйлгүй, жишээ нь, тэр ан агнуур, загас барих, гар урлалын гэх мэт ажил эрхэлнэ. Тэрбээр том биетэй, хөгжилтөй, нэлээд хөдөлгөөнтөй 45 орчим насны хүн байлаа.

Нэгэн орой өнөөх илбэч байрандаа цагтаа ирсэнгүй. Шөнө болж, гал асаан гэрэл тавьж, баримжаа өгч туземууд сандралын байдалд орлоо. Ширэнгэн ойд аюул ихтэй, жишээ нь, догшин урсгалт гол мөрөн олон, тар ирвэс мэтийн цус сорогч, зэрлэг амьтад, эсвэл гадаад төрхөөрөө энгийн ч намбикварын ой ухаанд ой усны савдаг, ад зэтгэр бологч амьтадтай таарч болзошгүй. Ийм сүнс, зэтгэр тааралдвал бүр ч аюултай. Тйнхүү бүтэн 7 хоногийн турш орой болгон нууцлаг омгийн гал холдож, ойртон байхыг бид хардаг байв. Танихгүй омог бүхний цаана аюул нуугдаж байдаг. Хоёр цагийн турш горьдлого тавин хүлээсний эцэст тэд бүгд нөхрийгөө бүгэгсэдэд баригджээ хэмээн итгэцгээж, түүний хоёр залуу эхнэр нөхрийнхөө, хүү нь эцгийхээ үхэлд гашуудан цурхиран уйлж байх зуур бусад тузем нөлөө бүхий хүнийг хүлээхээргүй эмгэнэлт үр дагаварыг тоочин хэлэлцэж байлаа. Оройн арван цагийн орчимд зайлшгүй болох сүйрлээс айх айдсаар дүүрэн хүлээлт, эмэгтэйчүүдийн харамсал гашуудалд бусад нь нийлж орь дуу тавих явдал, эрэгтэйчүүдийн сэтгэл зовнил зэрэг нь тэсэхийн аргагүй нөхцөл байдлыг бий болголоо. Иймд бид арай тайван байгаа хэдэн туземтай цуг эрэлд явцгаалаа. Хоёр зуун метр ч яваагүй байтал бид нэгэн хөдөлгөөнгүй биеттэй тулгарсан нь бидний хайж яваа хүн мөн байсан бөгөөд тэрбээр бугуйвч, зүүлт ч үгүй, сэгсийж,зэхийсэн байдалтай, шөнийн хүйтэнд даарч чичирчихсэн, бөхийж тонгойн сууж байв (намбиквар бүснээс өөр хувцас өмсдөггүй). Түүнийг байр руу нь хүргэн аваачихад тэр цааргалаагүй ч, бүгд түүнийг удаан гэгч нь ятган сэнхрүүлэх янзтай байж, бас ойр дотныхон нь түүний ярьж эхлэхийг мөн тийн гуйх аж. Түүний адал явдал бага багаар тайлагдаж эхлэв. Үдээс хойш энэ улирлын анхны их салхи босч, аянга цахилгаан бууж, түүнийг бидний байрлаж буй газраас хэдэн километрийн цаанах газар орноо аваачиж бид түүнийг олсон саяын газарт эргүүлэн авчирсан ажээ. Болсон явдлыг хэлэлцээд бүгд унтахаар хэвтлээ. Дараа өдөр нь аянга цахилгааны золиос этгээд маань дахиад л ерийн баяр баясгалантай байдалдаа орж, мөн чимэглэл зүүлттэйгээ болж(энэ нь хэний ч гайхлыг төрүүлсэнгүй), амьдрал ч хэв ерийн горимдоо орлоо.

Гэтэл хэд хоногийн дараа туземууд энэ ер бусын явдлын талаар өөр тайлбар сэлт ярилцах болов. Үйл явдал болж өнгөрсөн энэ бүл хүмүүс янз бүрийн гарал үүслээс бүрдсэн бөгөөд ямар нэгэн тодорхой бус байдлын улмаас нийгмийн шинэ нэгдэл бий болсон гэдгийг хэлэх хэрэгтэй. Тэдний нэг хэсэг нь хэдэн жилийн өмнө тахалд нэрвэгдсэн омгоос хэтэрхий цөөхүүлээ үлдсэн учир цаашид бие дааж амьдрахад хүндрэлтэй болсон, харин нөгөө хэсэг нь өөрсдийн төрөлх отог овгоосоо салж мөн тийм бэрхшээлийг тулсан аж. Гэхдээ энэ хоёр бүлэг хүмүүс хэзээ, ямар нөхцөлд уулзалдаж, хүчээ нэгтгэхээр шийдсэн, тэгэхдээ бүрдсэн нэгдэлд нэг тал нь ердийн амьдралын(хар талын) удирдагчийг, нөгөө хэсэг нь шашны толгойлогч тавьсан учрыг бид олж тогтоож чадсангүй. Гэхдээ ийн нэгдэх явдал саяхан болсон нь эргэлзээгүй, учир нь биднийг ирэх үед хоёр бүлгийн гишүүдийн хооронд ямар ч гэрлэлт байгаагүй, бөгөөд харин хүүхдүүд нь хүргэн бэр болохоор сүй тавьцгаасан байлаа. Хэдийгээр хамтын ахуй амьдралтай ч, тэдний өөрсдийн хэлний аялга хадгалагдаж, хоёр хэлтэй хоёроос гурван туземаар дамжуулж өөр хоорондоо харьцдаг байсан юм.

Зайлшгүй шаардлагатай байсан эдгээр тайлбараа дуусгаад адал явдалаа эргэн авч үзье. Туземууд өөр хоорондоо ийнхүү шивэр авир ярилцаж байлаа. Ойд бидэнтэй тааралдсан нөгөө үл таних бүлэг хүмүүс ч энд ирж нийлсэн нэг хэсгийг нь хуучин

отог овогт харъяалагдаж байсан бөгөөд илбэч, бөө ч тэдний бүрэлдэхүүнд байсан хэмээн хангалттай үндэслэлтэйгээр ярьж байв. Өөрийн хамтрагч нөхөр болох иргэний талын удирдагчийхаа эрх мэдэл, давуу байдалд санаархсан илбэч этгээд хуучин омгийхондоо гэмээ илчлэн буцан очиж, тэднийг шинэ нөхөд рүүгээ довтлохыг ятгах эсвэл, зүгээр л, шинэ нөхөд нь энх амгаланг эрхэмлэдэг гэдэгт хуучин овгийхноо итгүүлэхийн тулд тэдэнтэй холбоо тогтоохыг хүссэн нь эргэлзээгүй (мэдээж) юм. Юу ч болсон байлаа гэсэн түүнд эзгүй байсныг(алга болсон) нь тайлбарлах шалтаг хэрэгтэй байв, тэгээд ч аянга цахилгаанд өртсөн, түүний эрхшээлд орсон гэх жүжиглэлийг чухам энэ зорилгоор бодож зохиосон аж. Ийм тайлбар нь нөгөө бүлгийн тузем нарт тархаж, улмаар тэдний сэтгэл зовнилоор хөөрөгдсөн сүсэг итгэл үүнд нэмэр нэрмээс болж байв. Харин үйл явдлын энэ албан ёсны тайлбар нь нийгмийн өмнө хэзээ ч эргэлзээнд өртөөгүй, улмаар биднийг буцах хүртэл уг тайлбарыг бүгд онцлон дэмжсээр байлаа. (Levi-Straus C. Tristes Tropiques. P., 1955. XXIX бүлэг)

Эргэлзэгч хүмүүс уг үйл явдлыг өдөөсөн шалтгаануудыг психологийн нарийвлалтайгаар, улс төрийн зөн мэдрэмжтэйгээр задлан шинжилж, илбэч бөөгийнхөө үнэнч сэтгэл хийгээд хүч чадлыг эргэлзээнд оруулаагүй ч, хэрвээ энэ бүхэн нь тун үнэн төрхтөй байсан гэвэл тэд маш ихээр гайхах л байсан даа. Бөөгийн бусдыгаа хуурч худлаа ярьсныг нь зөвтгөж болохоор зүйл гэвэл гайхах байх. Тэр илбэч аянгын жигүүр хөлөглөн Ананаз голын эрэгт очоогүй нь мэдээж хэрэг, тэгэхээр энэ бүхэн ердөө л жүжиг байсан юм. Харин иймэрхүү зүйл өөр нөхцөл байдалд боломжтой ч, энэ нь туршлагын хүрээнд хамаарах учиртай. Бөө нь дээд тэнгэрийн хүчнүүдтэй ойр дотно холбоотой гэсэн итгэл үнэмшил байдаг, тухайн энэ тохиолдолд илбэч бөө хүч чадалд нь итгэх сүсэг итгэлийг ертөнцийн үйл явдлыг халхлахад ашигласан гэдэг нь таавар таамналын хүрээнд хамаарч байгаа бөгөөд түүхэн шүүмжлэл хэмээн нэрлэж болох тэр зүйлийн шалтаг далим болж байна. Боломжтой хоёр тохиолдол бие биенээ үгүйсгэхгүй байна гэдэг нь маш чухал баримт юм. Тухайлбал, бид дайныг үндэсний тусгаар тогтнолын эцсийн тэсрэлт, эсвэл их бууны наймаачдын ов залины үр дүн хэмээн өйлгөж-бөжнө, энэ хоёр тайлбар логикийн хувьд нэгдэх боломжгүй ч бид тус тусын тохиолдолд аль аль нь үнэн гэж үзэж байна. Яагаад гэвэл энэ хоёр тайлбар хоёулаа боломжтой бөгөөд бид нэгээс нөгөө рүү нь, мөн түүнчлэн холбогдох тохиолдол болон эгшин рүү нь хялбархан шилждэг, тэгээд ч олон хүний ухамсарт тэд хоёулаа ухамсаргүйгээр зэрэгцэн оршиж болдог. Баримтын эдгээр ялгаатай тайлбарыг чанд хатуу байдлаар үндэслэж болохгүй ч, хувь хүний ухамсарт бодот задлан шинжилгээнд ордоггүй, харин тэд тэнд эцсээ хүртэл гүйцэд томъёологдоогүй, бүрхэг бүдэг чиглэл удирдамжийн харилцан биесээ нөхөгч үр дагавар мөрдлөгийн байдлаар оршин байдаг, бидний хэн маань ч эдгээр чиг удирдамжийг хувийн туршлага дээрээ үндэслэн байна хэмээн бодож, баримтуудад хандахдаа сонирхон авч үзэж байдаг. Харин энэхүү хувийн туршлага нь тухайн бүлгийн соёл дахь аль нэг бүтцэд(системд) багтаагүй л бол ухамсартайгаар бүрэн хэлбэржээгүй, сэтгэл догдлын хувьд хүлээн авахааргүй байдалтай үлдэж хоцордог. Гагцхүү тэдгээр схемын нийцэл ижилсэл нь субъектив байдлуудыг объективчлох, хэлбэршээгүй сэтгэгдлийг томъёолох болон хүн бүрийн хувь туршлагыг нэгдсэн систем рүү оруулах боломж олгодог¹⁰⁸.

Энэ үзэгдлийн механизм нь билэг авъяаст шинжээч эмэгтэй М.К.Стивенсоны Шинэ Мексикийн Зуньи омгийхны дунд явуулсан ажиглалт судалгааны дүнд бидэнд улам бур ойлгомжтой болдог билээ.(801) Өсвөр насны нэгэн хүү гарыг нь барьснаас болж 12 настай охины мэдрэл гэнэт мууджээ. Охинд илбэ жатга хийсэн хэмээн хүүг буруутгаж, Лукын төлгөч нарын шүүхэд дууджээ. Цагийн туршид хүү далдын мэдэх чадвараа эрс үгүйсгэж байлаа. Гэвч хүүгийн өөрийгөө хамгаалах арга нь тус нэмэр болсонгүй. Тэр үед Зуньи омгийхон ховсодсон, илбэ жатга хийсэн хүнийг буруутай хэмээн үзэж цаазлан цээрлүүлэх ял тулгадаг байлаа. Хүү арга барилаа өөрчилж, урт

¹⁰⁸ Номон дахь хувийн(“би-санаашрал”) ба хамтын (“бид-санаашрал”) туршлагын задлан шинжилгээг харьцуулагтун.

түүх санаанаасаа зохиож ярив. Энэ түүхдээ хүү яаж ховсдох, илбэдэх чадварыг олж авснаа тайлбарлаж, охидыг галзууруулж, мөн тэднийг эдгээж чадах хоёр зүйлийг багш нараасаа өвлөн авсан гэж ярьжээ. Энэ яриа нь үйл явдал тааламжгүй чиглэл рүү өрнөхөөс овжин гэгч нь зайлуулж чадлаа. Залуугаас эдгээдэг увидас домоо харуулахыг шаардахад тэрбээр найдвартай хамгаалалттайгаар гэрээдээ явж хоёр үндэс авч ирж, тэдгээрийн шид хүчийг тэр дор нь харууллаа. Тэрбээр үнэхээр нарийн төвөгтэй ёс үйл гүйцэтгэлээ, тухайлбал, нэг үндсийг нь залгитал хүү яг л ухаан алдах шиг болсноо, нөгөөг нь амандаа хийтэл хэвийн байдалдаа орох нь тэр. Үүний дараа хүү өвчтэй охинд эм тангаа өгч, түүнийг эдгэсэн хэмээн зарлажээ. Үзүүлбэр ажиллагаа дараа өдөр хүртэл хойшлогдон завсарлаж, харин хуурамч илбэч шөнө дөлөөр зугтсан байв. Удсан ч үгүй түүнийг барьж авлаа, хохирогчийн гэр бүлийхэн ч өөрсдөө шүүх хурал үргэлжлэх нөхцөлийг бүрдүүллээ. Шүүхийн шинэ бүрэлдэхүүн өмнөх тайлбарыг нь хүлээн зөвшөөрөмгүй байгааг залуу мэдмэгцээ шинэ хувилбарыг санаанаасаа зохиожээ. Тодруулбал түүний бүх төрөл төрөгсөд, өвөг дээдэс нь илбэч бөө нар байсан бөгөөд энэ залуу муур болон хувирах, амаараа кактусын өргөс түүж, өргөсийг сум болгон амаараа буудаж золиосууд болох хоёр нялх хүүхэд, хоёр охин, хоёр хүүг егүүтгэх зэрэг хосгүй увидас чадварыг эцэг өвгөдөөсөө өвлөж эзэмшсэн гэж залуу баталжээ. Дэлхийн дээрх хөмөрсөн тэнгэрийг нэвтлэн гарахад тусалдаг ид шидтэй өд хүү болон түүний ойр дотныхонд байдаг гэнэ. Энэ тайлбар тактикийн алдаа болох нь тэр, яагаад гэвэл, шүүгчид ярианых нь нотолгоо болгож түүнээс өднүүдээ харуулахыг шаардсан юм. Янз бүрээр шалтгалж цааргалсан боловч залуу шүүгчдийг гэр лүүгээ дагуулж явахаас өөр аргагүй болжээ. Өдийг хана туурганд нуусан учир залуу хана өрлөгийг нураахгүй хэмээжээ. Гэвч бүгд л түүнийг нураахыг албадан тулгаж байлаа. Залуу ханыг эвдэлж хэлтэрхий болгоныг нь анхааралтай шалган нягталж байхдаа мартамхай болсноо ойлгуулахыг хичээж өдийг 2 жилийн өмнө нуусан бөгөөд хаана нууснаа мартсан гэв. Эрлээ үргэлжлүүлэхээс өөр аргагүй байдалд орсон тэрбээр хоёрдохь ханыг нураан, цаг орчим ажилласны дараа тоосгоны дотроос хуучин өд гарч ирлээ. Залуу шамдангуй нь аргагүй өдийг авч өнөөх ид шидтэй хэрэгсэл мөн хэмээн шүүгчдэд өгөв. Тэд өдийг хэрэглэдэг аргын талаар дэлгэрэнгүй ярихыг шаардлаа. Тэгээд залууг олны өмнө чирч гарган саяын ярьсан олон шинэ мэдээ баримт агуулсан үйл явдлыг эхнээс нь дэлгэрэнгүй ярьж өгөхийг тушаав. Залуу далдын хүчээ алдчихсан байна хэмээн гашуудан уйлж өөрийгөө зориуд дэндүү дорд үзэн яриагаа өндөрлөв. Тэгээд энэ харамслын яриаг сонсон итгэж үнэмшсэн шүүгчид залууг суллаж тавихаар шийдлээ.

Сэтгэл зүйн аливаа өнгө аясаас нь салгаж, товчлохоос өөр аргагүй байсан нь харамсалтай ч энэ яриа олон талаараа сургамжтай. Энэ нь юуны өмнө, илбэ ховсын үйл хийсэн гэдгээр буруутгагдаж, мөрдөгдөж, цаазын ялд унахыг завдан байсан этгээд гэм нүгэлээ үгүйсгэх байдлаар бус, харин хуурамч ял оноох(худал хуурмагаар гүтгэн яллах) гэж буйг ухаарч, өөрийн арга маягаа тохируулж байснаар цагаатгагдаж буйг бид харж байна. Тэр ч байтугай өмнөхөөсөө улам нарийн зүйл(тэгэх тусам гэмийн хувь хэмжээ ихсэх) санаагаар хачирласан тайлбаруудыг шил даран ярьсан нь өөрийнхөө байр суурийг бэхжүүлж, баттай болгож байна. Олон нийтийн өмнө болдог шүүн таслах ажиллагаа нь манайд байдаг шиг гэм бурууг тогтоон нотлох, эсвэл няцааж хэрэгсэхгүй болгох зарчмаар бус, харин шалтаг зааж, улам нарийвчилсан хэлбэртэй байв. Шүүгдэгч ямар нэг нотолгоог эсэргүүцэх тэр тусмаа янз бүрийн баримтыг үгүйсгэхийг шүүгчид сонирхдог ч үгүй. Тэд өөрсдөө ганцхан хувилбараар (ганц талаас нь) төсөөлж ойлгодог ёс журмын тогтолцоог зөвтгөн тунхаглахыг л шүүгдэгчээс шаарддаг, харин бусад зүйлт тайлбар сэлт нь уг журамд тохирч байхуйцаар хандахыг тэд түүнээс хүсч байдаг. Стивенсон шүүх ажиллагааны нэгэн үе шатны тухай тодруулан тэмдэглэхдээ, "Дайчин эрс мөнөөх залуугийн ярианд автан алмайрч, түүний шүүгдэж буй учир шалтгааны тухайд бүрнээ мартсан мэт байлаа" гэсэн байдаг. Залуу ид шидийн өдийг суга татан гаргаж ирэхэд дайчин эрс "энэ чинь юу болоод байна аа?" хэмээн нэгэн зэрэг уулга алдаж, гайхшралд орлоо. Тэд тэгээд залуугийн ярьсан зүйл үнэн гэдэгт эргэлт буцалтгүй итгэцгээв" хэмээн судлаач эмэгтэй тун гярхай тэмдэглэсэн байдаг. Гэмт үйлийг биетээр нотлох үед буй болдог ёслол баярыг бус, харин гайхшрал догдлолыг

дайчид мэдэрч байлаа. Шүүгчид гэмт үйлийг шийтгэхгүй, харин уг үйлийг боломжтой болгож буй журам тогтолцооны бодот байдлыг хангахыг эрмэлзэв. Ингэхдээ тэд бодот үндэслэлийг гэхээсээ энд холбогдон үүссэн сэтгэл догдлолын илэрхийллийг чухалчлав. Шүүх үнэнийг хамсан хүлээн зөвшөөрч, тэр нь улмаар бодот утгыг олж, яллагдагч өөрөө яллагчийн хамтран зүтгэгч болж хувирч байна. Үүний ачаар илбэ, ховстой холбоотой санаанууд тодорхой бус мэдрэмж хийгээд хэлбэржээгүй төсөөллийн нийлбэр болох ухамсарыг хүндрүүлэхээ больж, бодот ахуйг олж авдаг. Нотлон харуулж чадсаны учир шүүгдэгчийг өршөөж байна. Гэмтнийг шийтгэх үед үүсдэг шүүхийн ялан мандалт, ид бахыг бодвол санаанаас зохиосон зүйлээ үнэн юм шиг харуулж чадсан явдал нь овог бүлгийнхний хувьд зүйрлэмгүй тансаг сайхан мэдрэмжийг өгч байна. Тэгэхээр, хамгаалалтын ур авьяасынхаа ачаар, өөрийнхөө тайлбар, журам тогтолцооны (сонголт нь энэ болон өөр журам тогтолцооны хооронд биш, харин ид шидийн/маги/ систем хийгээд байхгүй систем болох хаос хоёрын хооронд хийгдэж байгаа болохоор) үнэн гэдэгт хүмүүсийг алхам алхмаар ятган итгүүлсэн залуу овог бүлгийнхээ аюулгүй байдалд учирсан заналхийллээс тэдний оюун санааны нэгдлийн баталгаа болон хувирч чадлаа.

Гэхдээ өөрийгөө хамгаалсан энэ байдал нь зөвхөн зохиомжлох чадвараараа онцгой байсан төдий биш ээ. Онож тохирсон арга барилыг барим тавим байдлаар болгоомжтой гэгч нь эрж хайж буй шүүгдэгч чухамдаа жүжигчилсэн тоглолт хийж, түүнд нь шүүгчид ч автаж байгаа сэтгэгдэл төрүүлж байна гэвэл хэтрүүлэг биш юм.¹⁰⁹ Түүнийг илбэч бөө мөн хэмээн олон нийтэд зарлан мэдээлдэг, нэгэнт тийм хүмүүс олон байдаг болохоор энэ этгээд ч илбэч байж болохсон билээ. Тэгэхээр ямар шинж тэмдгүүд нь түүний оноо тавиланг ийнхүү урьдчилан нээж өгнө вэ?

Магадгүй, энэ зөрчилдөөнд л түүний оноо тавилан илэрсэн биз. Түүний нотолгоо нь татвалзах өвчтөй охины хувь заяаг шийдэх явдал байв. Залуугийн хувьд тогтолцооны нэгдэл болоод охиныг эдгээхэд түүний оногдсон үүрэг нь энэ адал явдлаараа эрсдэлд орж буй түүний хувийн аюулгүй байдлаас илүү чухал байв. Бусдын нүдэн дээр тэрээр гухайн үүрэгтээ тохирсон дүрийг зальжин атлаа бүрнээ үнэн сэтгэлээсээ аажмаар бүтээж; янз бүрийн арга залиг хэрэглэж, зан үйлийн олон зүйлийг зохиож байлаа. Түүний оронд хэн ч байсан гүйцэтгэхчид чадах тийм л үүргийг Квесалид биелүүлэхийг хичээж байлаа. Энэ үйл явдлын төгсгөлд баатар маань яагаад эхнийх шигээ хуурамч дүр төрхтэй болов, мөн тэр үнэхээр ид шидтэн болсон болов уу гэх зэрэг асуулт нь тодорхойгүй юм. Залуугийн нүглээ наминчилсан талаарх тэмдэглэлд бид үүнийг уншсан юм. Үүнд, залуу ярих тусам өөрийн ярианы сэдэвтээ гүнзгий нэвтэрч байлаа. Цаг хугацаа өнгөрөх тусам сэтгэл хангалуунаар царай нь гэрэлтэж хүмүүсийг эзэмдэж байлаа. Эм уугаад эдгэсэн охин, ер бусын сорилтоос олсон туршлага нь нэгдсэн тогтолцоог бий болгож юунд ч буруугүй хүүг өөрийн далд хүч чадалдаа итгэхэд тус нэмэр болжээ. Түүний хүч чадалд нийгэм аль хэдийн итгэсэн байлаа.

Бид одоо өнөөг хүртэл зөвхөн хэл шинжээчдийн анхаарлыг татаж байсан нэгэн үнэтэй баримтанд анхаарлаа хандуулъя. Үүнийг Квакиютль(Канадын Ванкувера район) хэл дээр бичигдсэн нэгэн уугуул хүний намтраас хэсэгчлэн авсан юм. Үүнийг Франц Боас үгчлэн орчуулжээ. Квесалид (энэ нэрийг тэр бөө болсныхоо дараа олж авсан) домчын (эсвэл бөөгийн*, энэ нэр томъёо нь дэлхийн зарим нэг улс орнуудад байх онцлог үйл хэрэг юм) хүч чадалд итгэдэггүй байлаа. Тэрээр бөө нарын хууралтыг илрүүлж, нууцыг нь мэдэх зорилгоор тэдний дунд орохоор шийджээ. Энэ нь бөө нарын нэг нь Квесалидыг өөрсдийн бүлэгт элсэхийг санал болготол үргэлжлэхээр байлаа. Тэдний хүрээнд элссэнээр нууцыг нь мэдэж, маш хурдан тэдний нэг нь болох юм. Квесалид тэднээс гуйхыг хүчилсэнгүй, харин тэр анхны хичээлээ дэлгэрэнгүй дүрсэлж

¹⁰⁹ Зуньи омгийхны шүүх ажиллагааны туршлага нь дундад зууны ведьмүүдийн(шуламын), мөн арай хожуу үеийн тэдэнтэй адил төстөй хувилбаруудын үйл ажиллагаатай сэтгэл зүйн хувьд зэрэгцэж байгаа юм.

* Цаашид энэ хэллэгийг хэрэглэх болно.

тайлбарласан юм. Энэ нь туршлагын мэдлэг, гарын мэдрэмж, үггүй жүжгийн ер бусын цогц нийлбэр байлаа. Квесалидыг муужирч ухаан алдаж унасан мэт жүжиглэх, ид шидийн дууг дуулах, мөн бөөлжис амнаасаа гаргах зэрэгт сургажээ. Мөн тэр аускультацын (сонгон сурах) болон эх барих үйл явцын талаарх тодорхой ойлголтуудыг авчээ. Бас "далд харагсдыг" хэрхэн ашиглахыг, өөрөөр хэлбэл омгийн гишүүдийн өвчлөлтийнх нь онош, үндсийн зарим нэг зүйлийг бөөд нууцаар мэдээлэх үүрэгтэй тагнуулчдыг ашиглах гэсэн үг. Ялангуяа Номхон далайн баруун хойд эрэг дэхь бөөгийн урсгал чиглэлүүдийн нэг болох *ars magna**-г эзэмших нь түүнд их чухал байлаа. Энэ нь үсний тасархайг амандаа зууж хэрэгтэй үедээ хэлээ зүсэж цус гарган, цустай шүлсээ нулимаж өвчтөний муу зүйлийг хаяж байгаа мэт үйл хийх байлаа.

Квесалид баталгаажуулсан мөрдлөгөө үргэлжлүүлэхийг шийдсэн боловч аль хэдийн эрх чөлөөгүй болжээ. Түүнийг бөөгийн ёсонд суралцсаныг олон хүн мэджээ. Үүнээс болж нэг өвчтөний гэр бүл түүнийг аврагч хэмээн үзэж гэртээ урьжээ. Квесалидын энэхүү анхны эмчилгээ нь (түүнийхээр, энэ нь төлбөргүй бөгөөд учир нь тэр 4 жилийхээ хугацааг дуусаагүй юм байна) их амжилттай болжээ. Энэ бүхний дараа Квесалидыг агуу бөө хэмээн өргөмжилсөн ч тэр бөөгийн ёсонд шүүмжтэй хандсаар л байлаа. Квесалидыг өвчтөн зүүдэндээ харж улмаар үүндээ гүнзгий итгэсэн тул эдгэрсэн хэмээн уг амжилтаа тэрээр сэтгэл зүйн шалтгаанаар тайлбарлаж байлаа. Түүний үгээр энэ талаар дахин сайн бодох хэрэгтэй ба түүнд тохиолдсон энэ хүндрэлтэй асуудал нь далдын хуурмаг зүйлийг олон янзаар ойлгоход хүргэжээ. Квесалид зарим нэг далдын хуурмаг зүйл нь нөгөө хэсгийгээ бодвол арай бага хуурч мэхлэх чанартай гэсэн дүгнэлтэд хүрчээ. Үүнд түүний ухамсарт аажмаар бүрэлдэж буй тогтолцооны сонирхол татаж буй зүйлүүд орох нь зайлшгүй.

Квесалид хөрш овгийнхоо нэртэй бөө нарын анагаах үйлд байлцах үедээ барил тавилын ялгааг олж харсандаа ихэд гайхжээ. Тухайлбал, цустай хорхой байдлаар өвчнийг хялгас нуусан амнаасаа нулиман хаяхын оронд нөгөө бөө нар харин гар дээрээ ердөө л жаахан шүлс хахиран нулимаж, үүнийгээ өвчин хэмээн баталж байлаа. Энэ арга барил нь хэр үнэ цэнэтэй вэ? Ямар онолтой дүйцэж байна вэ? Энэ бөө нарын далдын хүчийг хэр үнэний хувьтай болохыг, юунд энэ далдын ид шид оршиж байгааг, эсвэл тэд бусад бөө нарынхаа адил худал дүр үзүүлж байгаа зэрэгийг мэдэж учирыг нь олох зорилгоор Квесалид өөрийн арга барилыг хэрэглэхийг санал болгожээ. Бусад бөө нарынх нь эмчилгээ үр дүнтэй болсонгүй. Ингээд эцэст нь Квесалидын эмчилгээний үр дүнд л эдгэрсэн хэмээн өвчтөн зарлажээ.

Ингээд манай гол дүрийн баатар маань анх удаагаа эргэлзэж эхэлжээ. Өнөөг хүртэл тэр өөрийн арга барилын хуурмаг үзэгдлийг дэмждэггүй байсан хэдий ч үүнээс илүү худал хуурмаг, мэхлэн төөрүүлэгч үнэнч бус арга барилыг олж харжээ. Тэр өөрийн түншүүддээ ядаж л ямар нэг зүйлийг өгч чаддаг. Тухайлбал, тэр өвчнийг бэлэн харагдаж мэдэгдэхүйц хэлбэрээр харуулдаг бол хөрш овгийн бөө нар юу ч харуулдаггүйгээр барахгүй зүгээр л өвчнийг олж илрүүлсэн хэмээн баталдаг. Ийм учраас Квесалидын арга барил нь үр дүнд хүрсэн, харин бусад бөө нарын арга барил үр дүнд хүрээгүй юм. Тиймэрхүү байдлаар манай гол баатар орчин үеийн шинжлэх ухаантай ижил төстөй байж болохоор асуудалтай тулгарч байгаа юм. Үүнд хоёр тогтолцоо байна. Мэдээж хоёулаа хоорондоо адилгүй гэдэг нь ойлгомжтой. Гэвч логик болон туршилтаар тэдний ялгааг онцлох шинжтэйг харуулжээ. Ямар тогтолцоонд тэднийг харьцуулж болох вэ? Хоорондоо үл ялгарах баримтуудын харьцаанд уу? Эсвэл тэдний онолын болоод практик үнэлэмжийн ялгааг бий болгодог дотоод тогтолцоонд уу?

Яг энэ үед нөгөө овгийн гишүүдийнхээ итгэлийг алдаж гутамшиг болсон бөө нар мөн эргэлзээнд автлаа. Тухайлбал, тэд өвчнийг ямар нэг харагдахаар зүйл мэт үзүүлэхийг оролдож ч байгаагүй бөгөөд харин оюунлаг чанартай гэж үзэж байсан

* "агуу урлаг" гэсэн латин үг.

өвчнийг Квесалид бодит орших зүйлээр харуулсан юм. Бөө нар нэгэн агуйд нууцаар уулзъя хэмээн Квесалид руу элч илгээжээ. Квесалидыг тэнд ирэхэд мөнөөх бөө нар түүнд өөрсдийн тогтолцоог ярьжээ. Тухайлбал, хатиг, яр, ходоодны өвчин, давсаг агших, загатнаа, хомхруу, батга, тамир тэнхээгүй болох, түүхий булаг зэрэг бүх өвчнүүд хүний сэтгэл байдаг. Бид хүний өвчний сэтгэлийг барин авангуут өвчний бие нь бидний дотор үхэж алга болдог. Хэрэв энэ онол зөв бол юугаа харуулах юм бэ? Ямар учраас Квесалидын гаранд өвчин наалдаж үлдэв хэмээн асууцгаажээ. Гэвч Квесалид дөрвөн жилийн дадлагаа дуусаагүй учир хүн сургаж болохгүй гэсэн мэргэжлийн хуулиа сахих хэрэгтэй учир нууцаа ярихаас татгалзжээ. Бөө нар Квесалидын толгойг эргүүлж, нууцыг нь мэдэхийн тулд түүн лүү онгон охидуудаа хүртэл явуулж байсан хэдий ч тэрээр байр суурин дээрээ бат зогссоор л байлаа.

Ингээд Квесалид өөрийн төрсөн тосгон Форт Руперт руу эргэн иртэл хөрш овгийх нь хамгийн нэртэй бөө түүний өсөн нэмэгдэж буй нэр хүндэд атаархан, түүнд итгэхгүй байгаагаа илэрхийлж өвчтөнийг эмчлэх үйл хэрэгт хүч чадлаараа тэмцэлдье хэмээн урьжээ. Товлосон газартаа Квесалид ирж нөгөө ахимаг насны бөөгийн хэд хэдэн эмчилгээний үйлд байлцлаа. Гэвч тэр мөн л өвчнийг хангалттай баримтаар үзүүлж чадахгүй байлаа. Тэр өвчин гэж нэрлэсэн харагдаж үзэгдэхгүй нэгэн зүйлийг холтсоор хийсэн малгайндаа эсвэл шувуун хэлбэртэй зан үйлийн хонхолдойндоо нууж байлаа. Домчын гарт юмуу эсвэл гэрийн тулгуур баганад шингэсэн өвчний хүч нь энэ зүйлүүдийг агаарт замхруулж байлаа. Тэрээр байдаг л нэг жүжиг тоглож байлаа. Энэ эмчилгээ нь бүтэлгүй, найдваргүй болсон тул Квесалидаас өвчнийг эмчлэхийг гуйжээ. Ингээд тэр өөрийн цустай хорхойгоо амнаасаа гаргаж ирэх аргаа хэрэглэснээр ялалтанд хүрчээ.

Үүнээс бидний өгүүллэгийн сэтгэл хөдлөгөсөн хэсэг эхэлж байна. Овгийн гишүүдийнхээ итгэл үнэмшлийг алдсан, өвчнийг анагаах арга нь үгүй болсноос ичиж зовсон ахмад бөө маань Квесалидыг болзож уулзъя хэмээн охиноо түүн рүү явууллаа. Квесалид нөгөө бөөг модны ёроолд сууж байхыг олжээ. Ахмад бөө Квесалидад хандан лийнхүү өгүүлжээ. “Бид энд бие биендээ муу муухай зүйл ярих гэж уулзаагүй. Харин чамаас намайг ичсэнээсээ болж үхлээс авраасай хэмээн би хүсэх байна. Яагаад гэвэл би өнгөрсөн шөнө чиний хийсэн зүйлээс болж түмний элэг доог болсон. Би чамаас намайг өрөвдөж, тэр шөнө чиний гарын алганд юу зууралдаж байсныг хэлэхийг хүсэж байна. Энэ үнэхээр өвчин байсан уу, эсвэл энэ нь санаанаасаа зохиосон зүйл үү? Би чамаас үүнийгээ яаж хийснийг хэлж өгөөч гэж хүсье. Дараа нь би чамайг дуурайж хийе. Намайг өрөвдөөч дээ” хэмээжээ. Квесалид эхлээд дуугүй сонсож байснаа харин дараа нь бөөгийн малгай болоод хонхолдой нь үнэхээр ид шидийн хүчтэй эсэхийг тайлбарлахыг түүнээс шаарджээ. Тэгэхэд бөө түүнд малгайндаа нуусан үзүүртэй зүйлийг харуулаад энэ нь овоохойн баганын баруун булан луу хатгахад тус болдог ба бас хонхолдойныхоо толгойг хурууныхаа завсар бэхэлж шувуу хошуугаараа түүний гарнаас зуурсан мэт сэтгэгдэл төрүүлдэг хэмээжээ. Тэр худал ярьж хууран мэхэлж, ашиг олохын төлөө, өвчтөнүүдийн эд хөрөнгөнд шунасандаа бөө болж жүжиглэдэг ба хүний сэтгэлийг эрхэндээ оруулж чадахгүй гэдгээ сайн мэддэг. Яагаад гэвэл хүн болгон өөрийн гэсэн сэтгэлтэй. Тиймээс энэхүү бөө маань амьтны өөхийг ашиглан үүнийгээ хүний сэтгэл хэмээн баталдаг байна. Түүний охин нь мөн эцгийхээ өмнөөс цаашид амьдрахад нь тусалж түүнийг өрөвдөхийг гуйж байлаа. Гэвч Квесалид урьдынхаараа дуугуй л байлаа. Ингээд энэ эмгэнэлт уулзалтын дараа нөгөө хөгшин бөө “зүрхэндээ өвчтөй” өөрийн ойр дотны хүмүүстэй хамт, овгийн бусад гишүүд нь түүнийг амиа хорлох вий хэмээн санаа зовж эхлэхээс өмнө тэр шөнөө ор мөргүй алга боллоо. Харин бөөгийн энэ өөрийгөө аварсан нь нэмэр болсонгүй. Тэр жилийн дараа эргэн ирсэн боловч охинтойгоо хамт ухаанаа алдаж галзуурчээ. Ингээд жилийн дараа тэрээр нас барсан юм.

Харин Квесалид өөрийн карьераа үргэлжлүүлж нууцаа хэвээр хадгалан, худал хуурмаг хүмүүсийг илрүүлэн, өөрийн ажил үүргээ зэвүүцэн жигшсээр л байлаа. Тэр ийнхүү өгүүлжээ. “Би зөвхөн нэг л удаа сорох аргаар өвчтөнийг эмчилж буй бөөг харсан, гэвч тэр үнэхээр бөө байсан юмуу эсвэл хуурамч этгээд байсныг мэдэхгүй. Би түүний инээж байсныг хэзээ ч хараагүй” хэмээжээ. Харин түүний анхны сэтгэгдэл нь

мэдээж өөрчлөгдсөн. Тухайлбал, чөлөөт санаатны эрс буруушаалт нь олон янзын баялаг мэдрэмжүүдээр солигдсон. Үнэхээр төрөлхийн бөө байдаг юм. Тэр өөрөө төрөлхийн бөө мөн гэж үү? Өгүүллэгийн төгсгөлд энэ тухай яригдаагүй. Харин нэг мэдэгдэж буй зүйл нь гэвэл Квесалид өөрийн үйл хэргийг үргэлжлүүлж, амжилтаараа бахархаж бусад бөөгийн урсгал чиглэлийг дэмжин, цустай бөөн чандараа гэргэн үзүүлдэг арга барилаа хамгаалсаар байсан нь юм. Харин энэ арга нь зөвхөн ов мэх төдий зүйл ба тэр өөрөө ч гэсэн эхлээд үүнийгээ үл тоомсорлон шоолж байсан юм.

Дээр өгүүлсэн зүйлээс ид шидтэний сэтгэл зүй тийм амар зүйл биш гэдэг нь харагдаж байна. Үүнийг тайлбарлахын тулд эхлээд хөгшин бөөг санах хэрэгтэй. Тэрээр залуу өрсөлдөгчөөсөө түүний гарт наалдсан улаан хорхойнцорыг үнэхээр өвчин юмуу эсвэл энэ нь ямар нэг юмаар хийгдсэн зүйл байсан уу гэсэн асуултандаа хариулт аваагүйгээс болж ухаанаа алдсан юм. Энэ түгшүүртэй төгсгөлөөс өмнө хөгшин бөөгийн хувьд дараах зүйлүүд тодорхой байлаа. Нэг талаас өвчин эмгэгийг өөрийн гэсэн шалтгаантай, үүнийг нь илрүүлж болно гэж тэр үзэж байлаа. Нөгөө талаас тэр өөрийн хийж бүтээсэн олон зүйлийг багтаасан өвчнийг тайлбарлах тогтолцоог эзэмшин өвчний эхлэх үеэс эдгэрэх хүртэлх бүх үйл явцыг энэхүү тайлбараар тодорхойлж болно гэдгийг баттай мэдэж байлаа. Гурван зүйлийн туршлагын нэгдмэл хүч нь тодорхой бус бодит байдлыг үлгэр болгон хувиргасан юм. Нэгдүгээрт, бөөгийн өөрийнх нь туршлага, мэдээж тэр төрөлхийн бөө бол шүү дээ (туршлагаараа бөө болсон ч байж болно). Тэрээр сэтгэл зүйн шинж чанар онцлог байдлыг мэдэрч чаддаг. Хоёрдугаарт, өвчтөний дээрдэж буйгаа мэдэрч байна уу эсвэл мэдрэхгүй байна уу хэмээх туршлага. Гуравдугаарт, эмчилгээг ажиглаж буй гуравдагч этгээдийн туршлага. Үүнийг ажиглаж байх үедээ энэ этгээд улам зоригжиж, сэтгэлийн ханамж авдаг. Энэ нь эмчилгээний үнэнч байдлыг хүлээн зөвшөөрч буй нийгмийн үндэс болдог ба дараагийн үе шат руу хөтөлж өгдөг.

Бөөлөлтийн нэгдэл гэж нэрлэж болохоор энэ гурван зүйл нь хоорондоо нягт холбоотой юм. Харин эдгээр нь зөвхөн хоёр зүйлээр л ялгарч байгаа юм. Нэг талаас бөөгийн өөрийнх нь сэтгэл хөдлөл, нөгөө талаас нийгмийн сайшаал юм. Ид шидтэнүүд бол хамгийн үнэнч гэдэг нь эргэлзээгүй юм. Тэд өөрсдийн далд хүчинд итгэдэг ба энэ итгэл нь тэдний онцгой явдал дээрх бодит сэтгэл хөдлөл дээр үндэслэдэг. Тэдэнд учирч буй гачигдал бэрхшээл нь ийм байдлыг бий болгоход төдийгүй үйл хэргийнх нь үнэнч байдлыг баталдаг энэхүү зүйлийг хүлээж аваагүй ч байсан хангалттай юм. Эдгээрийг шууд гэрчилж чадах хэл шинжлэлийн баримтууд байдаг. Тухайлбал, Калифорны винту хэмээх нутгийн аялгуунд таван үйл үгийн төлөв байдаг¹¹⁰. Эдгээр нь үйлдлийн хаанаас урган гарч ирж буйг илэрхийлдэг. Жишээ нь, мэдрэхүйн замаар, хүртэх сэрэхүйн замаар, тунгаан бодох замаар, индукц гаргалгааны замаар, эцэст нь хүмүүсийн амнаас ам дамжих замаар. Энэ таван төлөв нь мэдлэгийн дүрэм категорид хамаарах ба үүнээс огт өөр хэлбэрээр илэрхийлэгддэг таамгийн категориос шал өөр зүйл юм. Далд ертөнцтөй харьцах харьцаа нь мэдлэгийн категорид хамрагдах төлвүүдээр илэрхийлэгддэг нь гайхалтай. Ялангуяа, хүртэх сэрэхүйн(өөрөөр хэлбэл, мэдрэмжийн зөн билэг) ба индуктив гаргалгааны төлөв зэргээр илэрхийлэгддэг. Оюун санааны хямралд орох үедээ уугуул хүн маань бөө болжээ. Дүрэм ёсоор бол тэр өөрийн энэ байдлаа ямар нэг онгодоос өвлөж авсан туршлага гэсэн баримтаас индукц хийсэн үр дүн хэмээн тайлбарладаг. Энэ бүхнээс бөө дүгнэхдээ, тэрээр далдын ертөнцөд аялан, дараа нь дахин иргэж ирдэг. Энэ нь түүний туршлагатай шууд холбоотой юм.

Өвчтөний бодит туршлагыг тийм ч их нөлөөтөй биш ч гэсэн бөөгөөр амжилттай эмчлүүлсэн өвчтөн дараа нь өөрөө бөө болоход илүү амар хялбар болдогоор тайлбарлаж болох юм. Иймэрхүү зүйл сэтгэл задлан шинжлэлд олонтой ажиглагддаг. Юутай ч гэсэн бөө маань түүний амжилтыг тайлбарлаж чадахаар эерэг шинж,

¹¹⁰ Хүмүүнлэгийн ухаанд нэг төрлийн баримтыг(хэлний) олон янзаар дүрслэхийг хооронд нь харьцуулах үнэлгээний янз бүрийн тогтолцоог үүсмэл дүрмийн онолд нарийвлан судалсан байдаг[37].

туршлагатай арга барилыг эзэмшдэг. Харин өнөөдрийн сэтгэл мэдрэлийн өвчтөй хэмээн нэрлэгдээд байгаа, ядуу буурай нийгэмд олонтой тохиолддог өвчнүүд нь сэтгэл зүйл (психопатия) хамрагдах ёстой. Ер нь бол туземын анагаагчид иргэншилт нийгмийн эмч нарын адилаар эмчилгээ хийдэг ба энэ харьцангуй ашигтай зүйлгүйгээр ид шидийн барил тавил нь бүх хугацааны турш, бүх тивүүдэд ингэж өргөн тархацтай байхгүй байсан. Харин энэ асуудал нь тийм чухал биш юм. Учир нь энэ нь хоёр өөр зүйлд хамааралтай. Тухайлбал, Квесалид өвчтөнийг эдгээсэн учир агуу бөө болоогүй, харин агуу бөө байсан учир өчтөнийг эдгээсэн юм. Ингээд бид одоо түүний эсрэг туйл болох хамтын хүчийг авч үзье.

Квесалидын өрсөлдөгч нарын уналтын шалтгааныг амжилт ба амжилтгүй гэсэн хамааралд хайх хэрэггүй, харин нийгмийн бусад гишүүдийн үйлдлээс хайх хэрэгтэй. Бөө нар өөрсдөө бусдын доог тохуу болсон учир тэднээс ичиж байна гэсэн. Харин ичих гэдэг бол нийгмийн мэдрэмж. Амжилтгүй байна гэдэг нь хоёрдугаар зэргийн асуудал юм. Дээр дурдсан бүх яриануудаас амжилтгүй байхын шалтгааныг өөр нэг зүйлээс гаралтай хэмээн үзэж байгаа нь харагдаж байна. Энэ нь огт өөр бөө, өөр тогтолцоо түрэн орж ирснээр үүссэн нийгмийн хамтын оролцоо үгүй болсонтой холбоотой. Тиймэрхүү байдлаар үндсэн асуудал бол хувь хүн болоод нийгмийн бусад гишүүдийн хоорондын харилцаа, тухайлбал хувь хүний тодорхой категори болон нийгмийн бүлгүүдийн тодорхой шаардлага хоорондын харьцаа зэрэг нь юм.

Өөрийн өвчтөнөө ашиглаж бөө нь хүмүүсийн өмнө жүжиг тоглодог. Ямар жүжиг? Зарим нэг ажиглалтанд болгоомжгүй дүгнэлт өгөхгүйн тулд энэ жүжиг бол бөөгийн уриа дуудлагын дахин давтах үйл явц бөгөөд өөрөөр хэлбэл, түүний авъяас чадал нээгдсэн анхны уналт давтагдаж буй явдал юм хэмээн үзэх нь зүйтэй юм. Гэвч жүжиг гэсэн үг нь төөрөгдөлд оруулах ёсгүй бөгөөд бөө нь зөвхөн нүүрний хөдөлгөөнөөрөө үйл явдлыг үзүүлдэггүй, харин эдгээр үйл явдлыг амьдаар нь, давтагдашгүй байдлаар, жинхнээр нь харуулж чаддаг. Харин зан үйл дуусах үед тэр этгээд хэвийн байдалдаа ордог бөгөөд тэрээр сэтгэл зүйн үндсэн нэр томъёо болох "хариу үйлдэл" хийж байна хэмээн хэлж болно. Сэтгэл судлалд хариу үйлдэл гэдэг нь өвчтөн дахин түүний өвчнийг бий болгосон нөхцөл байдлыг мэдэрч эцсийн эцэст энэ нь өвчнийг нь анагааж буй тэр шийдвэрлэх мөч юм. Энэ утгаараа бөөг мэргэжлийн хариу үйлдэгч хэмээн ойлгож болно.

Өөр нэг жишээн дээр бид нэгэн таамгийг олохыг хичээсэн. Энэ таамаг нь бөө болон тодорхой бөөгийн урсгал чиглэлийн хувьд яг ямар аргаар хариу үйлдэл хийх нь өвдөж гэмтсэн өвчтөнд тэмдэгийн тусламжтайгаар эдгэрэхэд нь тусалдаг юм бэ гэсэн асуултанд хариулж болох юм [см.481- нас.изд.,глX]. Энэ тохиолдолд үндсэн асуудал нь бөө болон нийгмийн хоорондын харилцаа байсан бол харин энэ асуудлыг эрүүл ба эмгэг сэтгэлгээний харьцаа гэсэн арай өөр өнцөгөөс нь харж болох юм. Ямар ч байсан шинжлэх ухаанч бус байр суринаас (харин ямар ч нийгэм түүнгүйгээр гайхуулах зүйлгүй болох билээ) үзвэл өвчтөй болон эрүүл сэтгэхүй нь бие биедээ харшилдаггүй, харин нэг нэгийгээ нөхдөг юм. Эрүүл сэтгэхүй бол үргэлж дэлхий ертөнцийг танин мэдэхийг эрмэлздэг ба ертөнцийн хуулийг хэзээ ч төгс эзэмших бололцоогүй байдаг. Ингэснээрээ эрүүл сэтгэхүй байнга хүрч болшгүй зүйлийн утга учирт хүрэхийг эрмэлздэг. Харин эмгэг гэж нэрлээд байгаа сэтгэхүй нь эсрэгээрээ олон тайлбар, сэтгэл хөдлөлийн хариултуудыг өөртөө багтааж түүгээрээ тийм ч баялаг бус бодит байдлыг хангалттай, бүр хэтэрхий хангаж өгдөг. Нэгнийх нь хувьд туршлагатай тохирохгүй өөрөөр хэлбэл өшөө илүүг шаардах орон зайнд үлдэж хоцорсон үзэгдлүүд байдаг бол харин үргэлж тохирох объектгүй байдаг туршлагат эмгэг сэтгэхүй нь бэлэн зүйлээр үргэлж илүүддэг. Хэл шинжлэлийн хэлээр бол эрүүл сэтгэхүй нь онож илэрхийлж чадахгүйгээсээ ямагт буруу зөрүү болдог, үүнтэй зэрэгцэн эрүүл бус сэтгэхүй нь (гэхдээ бүхэлдээ биш зөвхөн зарим нэг илрэлээр) юмыг илүүдүүлэн утгачилж боддог. Хамтын оролцооны тусламжтайгаар бөөгийн эмчилгээ нь энэ хоёр нөхцөл байдлыг тэнцвэржүүлдэг. Учир нь эрүүл сэтгэгчтэй хүн өвчний учрыг ойлгодоггүй тул нийгэм эрүүл бус сэтгэгчтэй хүний арвин баялаг сэтгэл хөдлөлийг эмчилгээнд ашиглахыг илүүд үздэг ба энэ арвин баялаг сэтгэл хөдлөл нь ийм зүйл хийхгүй бол ор мөргүй алга болно гэсэн үг. Сэтгэл судлалын

үүднээс жинхэнэ эрэлт ба нийлүүлэлтийн тэнцвэр үүсч байгаа юм. Гэхдээ зөвхөн хоёр нөхцөлд л энэ тэнцвэр нь бий болдог. Нэгдүгээрт, нийгмийн уламжлал, хувь хүний санаанаасаа зохиосон зүйл хоёр нийлж ямар нэгэн уян хатан бүтцийг, өөрөөр хэлбэл нөхцөл байдлын бүхий л хэлбэрийг өөртөө агуулсан тогтолцоог бүрдүүлэх ёстой бөгөөд энэ тогтолцоо нь бөө, өвчтөн, ажиглагч, эмчилгээний үйл явц, төсөөлөл зэргийг зэгцэлж байр байранд нь оруулдаг. Хоёрдугаарт, энэхүү бэлгэдлийн илрэл болох бүхэл бүтэн ертөнцийг мэдрэх мэдрэмжид хариу үйлдэл хийх үйл явцад зөвхөн бөө болон өвчтөн биш, мөн ажиглагчид оролцох ёстой. Үүнд өвчтөн өвчний хүчээр, бөө сэтгэл мэдрэлийн эмч гэсэн утгаараа байнга оролцдог. Тэд хоёулаа тодорхой мэдрэмжийн туршлагатай байдаг ба энэ туршлага нь бэлгэдэл гэсэн утгаараа бүрэн илэрхийлэгдэж чаддаггүй ч, гагцхүү үүний л тусламжтайгаар бөө болон өвчтөн маань ядаж холоос, энэ ертөнцийн туяагаар¹¹¹ ч хамаагүй мэдрэмжээ илэрхийлж чаддаг юм. Нэг их шаардагдаад байдаггүй бараг хэрэггүй зүйл болох туршлагаар шалгаж үзэх боломжгүйгээс энэ харьцангуй баялаг зүйл нь ямар нэг туршлага хуримтлуулж буй бөө эсвэл бөөгийн урсгал чиглэлд нэвтрэн орох, мөн зарим нэг боломжит тогтолцооноос сонголт хийх бололцоог олгодог байна¹¹².

Дээр өгүүлсэн зүйл нь шинжлэх ухааны тайлбарыг бодвол ямар нэг объектив шалтгаантай төсөөлөл, сэтгэл хөдлөлийн эмх замбараагүй байдлын холбоог бий болгохдоо биш харин ямар нэг бүхэллэг зүйлийн чанарыг илэрхийлэх тухай, эсвэл энэ бүрхэг(заримдаа тасалданги чанараас үүдсэн хүнд хэцүү) байдлыг нэгтгэх эсвэл тодорхой төвшинд барих боломжийг олгодог тогтолцоог бий болгох тухай тус тус авч үзсэн. Ялангуяа энэ тасалданги чанар нь гаднаас авах боломжгүй суурь туршлагын төлөв байдлыг хүлээж авахыг оюун ухаанд тулгадаг. Нэмэлт сэтгэл зүйн зөрчилдөөний улмаас бөө болон өвчтөн хоёр ямар ч сэтгэхүйд байдаг нийгмийн нүдэн дээр тодорхой хэрэгжүүлдэг харшилдах зүйл болдог хослолыг бий болгодог. Энэ харшлах зүйлийн энгийнээр ойлгох аргагүй юм. Тухайлбал, өвчтөн өөрийн "би"-гээр дутагдсан идэвхгүй талыг илэрхийлдэг. Учир нь хэлбэржээгүй зүйл бол сэтгэхүйн өвчин юм. Харин ид шидтэн, домч бол өөрийн "би"-гээр илүүдсэн идэвхитэй талыг илэрхийлдэг. Учир нь ашигтай байдал бол бэлгэ тэмдгүүдийн эх ундарга нь болж байдаг. Эмчилгээний үед энэ хоёр туйлын тэнцвэржилт, нэгээс нөгөөд шилжих шилжилт явагдаж байдаг. Ерөнхийдөө тэцвэржилт нь оюун санааны ертөнцийг нэгтгэж, энэ оюуны ертөнц нь нийгмийн амьдралын загвар болж байдаг.

Иймэрхүү янзаар "хариу үйлдэл" гэсэн ойлголтыг илүү өргөн утга төгөлдөр болгох шаардлагатай ба бусад сэтгэл судлалын чиглэлүүдэд энэ нь огт өөр утгаар хэрэглэгддэг. Сэтгэл судлалын нэг хийсэн гавъяа нь энэ ойлголтын үндсэн утгыг нээсэн явдал юм. Ер нь сэтгэл задлан шинжлэлд гурав биш, зөвхөн нэг л өвтөний хийж буй хариу үйлдэл байдаг гэж хэлэхэд болох болов уу? Энэ нь одоогоор тийм ч тодорхой биш байна. Эмчилгээний үед бөө дуугүй байгаа өвчтөнийхөө оронд хариу үйлдэл хийн ярьдаг, харин үүнтэй адил сэтгэл задлан шинжлэлд өвчтөн түүнийг сонсож буй эмчийнхээ хяналтанд өөрөө өөртөө хариу үйлдэл хийж ярьдаг нь үнэн юм. Тэр тусмаа өвчтөний хариу үйлдэл хийж буй хугацаатай давхцахгүй байгаа эмчээс мөн хариу үйлдэл хийхийг шаарддаг байна. Учир нь сэтгэл задлан шинжээч байхын тулд өөрөө задлан шинжлэлд оролцох хэрэгтэй. Сэтгэл задлал болон шид, домын үйлийн үүрэг ролийг тодорхойлоход жаахан хүндрэлтэй байдаг. Учир нь шид домын үйл нь өвчтөний

¹¹¹ Оросоор "отблеск" гэсэн энэ үг нь англиар illuminations ("озарение", "гэрэлтүүлэх") гэж орчуулдаг ба А.Рембогийн энэхүү ер бусын үзэгдлийг яруу тодоор илэрхийлсэн шүлгийн эмхтгэлийг ийнхүү нэрлэдэг юм байна.

¹¹² Мишель Лейрисын шүүмжлэлт өгүүлэл нь намайг төстөй байдлын тухай асуудлыг тодорхой болгох хэрэгтэй юм байна гэсэн санаа руу хөтөлсөн юм. Марсель Моссын бүтээлүүдийн эмхтгэлд хийсэн удиртгалдаа би энэ тухай дурдсан билээ. Харин энд зөвхөн илбэч домч ба сэтгэл мэдрэлийн эмч(невротик) хоёрын хоорондын төстөй чанарыг л тусгасан билээ.

тусламжтайгаар урьд нь байж байсан нөхцөл байдалтай нийгмийг зохицуулдаг. Харин сэтгэл задлан шинжлэл нь гаргасан шийдвэрийхээ тусламжтайгаар нийгэмд өвчтөнийг буцаан авчирдаг. Харин сүүлийн үед шинжлэх ухаанаар батлагдсан таамаглалаас бүрдсэн сэтгэл задлан шинжлэлийн тогтолцоог ямар нэг тодорхой бус, нийгмийн оюун санаанд(эрүүл бус сэтгэхүйгээр боловсрогдож буй тайлбарын тогтолцоог өргөн хүрээтэй болгох гэсэн субъектын хүсэл эрмэлзлэлээр объектын үзэгдлийг тайлбарлах, мөн хувь хүний сэтгэлгээг задлан шинжлэхэд хэрэглэгддэг аргыг нийгмийн сэтгэлгээний үзэгдэлд хэрэглэж, эрүүл бус сэтгэлгээг эрүүл сэтгэлгээ рүү шилжүүлж) буй домог зүйд хамааруулах гэсэн түгшүүртэй хандлага ажиглагдаж байгаа юм. Ингэснээр ид шид, домын үйл ба сэтгэл задлан шинжлэл хоёрын зэрэгцэх аюул тулгараад байгаа юм. Тиймээс(магадгүй бүр одоо) зарим нэг улс оронд сэтгэл задлан шинжлэлийн гол зүйл нь түүний хүнд тусалж буй чадвар нь биш, харин нийгмийн бүлгийн аюулгүй байдлыг хангагч, эмчилгээний суурь арга барил болох домог юм. Сэтгэл задлан шинжлэлийн хувьд хамгийн голлох байр суурийг эзэлж буй зүйл бол хүмүүсийн сайн мэддэг домгийн тогтолцоо байдаг. Энэхүү домгийн тогтолцоон дээр тулгуурлан нийгмийн бүлэгт дахин шинэ ертөнц бий болдог.

Өнөөдөр сэтгэл задлан шинжлэлийн арга болоод урьд нь өргөн хэрэглэгдэж байсан сэтгэл судлалын арга барилыг хооронд нь харьцуулах нь энэхүү аргууд болоод түүний суурь зарчмуудаас чухал дүгнэлт гаргахад тус нэмэр болдог юм. Сэтгэл задлан шинжээч зөвхөн сэтгэл мэдрэлийн өвчтөнүүдтэй төдийгүй нийгмийн бүлгийн энгийн төлөөлөгч нартай ажиллаж хүрээгээ тэлснээр эмчилгээнээс харилцаа хандлага руу шилжиж байгаа юм. Тухайлбал, орчиндоо маш муу тасан зохиогч болоод сэтгэл санааны тогтворгүй хүнийг зөвхөн ятгаж л эмчилж болох юм. Эмчилгээ нь (эмчийн санаа зорилгоос үл хамаарсан) сэтгэл зүйн эмгэг болоод түүний шалтаг шалтгааныг нь ор мөргүй арилгах бус, харин сэтгэл зүйн тайлбараас шалтгаалан өвчтөний мэдрэмжүүдийг дахин шинээр сэргээхэд л байдаг гэдэг нь бодьтой аюул юм. Тиймээс дээр шинжилсэн ид шид, дом-нийгмийн тогтолцоо үүсэх онолын боломж нээгдэж байна гэсэн суурь үзэл рүү бид ирж байгаа юм.

Хэрэв энэхүү дүгнэлт нь зөв бол ид шид, домын үйлд нөхцөл байдалд хэрхэн хариу өгөхийг нь харах хэрэгтэй. Энэ нөхцөл байдлыг ухамсар цухалдангуй хүлээж авдаг боловч энэхүү нөхцөл байдлын мөн чанар нь оюун ухааны хүрээнд байдаг. Зөвхөн бэлгэ тэмдгийн үүрэг нь хүний оюун ухааны хувьд дэлхий ертөнц байнга тийм ч хангалттай утга учиртай байдаггүй, харин ерөнхийдөө ухаан бол агуулж буй зүйлээсээ илүү их боломжийг өөртөө багтаадаг гэсэн тайлбарыг хийх боломжийг олгож байгаа юм. Илэрхийлэх болон илэрхийлэгдэж байгаа хоёр тогтолцооны дунд оршин буй хүн ид шид-домын сэтгэхүйн тусламжтайгаар эсрэг тэсрэгээс баримт хүртэлх зүйлүүдийг өөртөө агуулсан гуравдагч тогтолцоог олж авдаг. Гэвч энэхүү гуравдагч тогтолцоо нь танин мэдэхүйг халснаар үүсч хөгждөг. Танин мэдэхүй хөгжихийн тулд эхний хоёр тогтолцооны зөвхөн нэг нь л хөгжих шаардлагатай ба энэхүү тогтолцоо нь нөгөө хоёрдогч тогтолцоог бүрэн хэмжээгээр уусгаж чадсан байх тийм нөхцөл байдалд (бид үүнд хүрэхэд маш хол байгаа) гүнзгийрэн орж боловсрогдох ёстой. Эрүүл ч бай, эрүүл бус ч бай хувь хүн бол нийт хүн төрөлхтний алдааг давтах ёсгүй. Хүн ямар ч тохиолдолд хоорондоо зөрчилтөй тогтолцоонуудыг ашигладаг ба энэ зөрчлөөс болж хүн ямагт төөрч будилдаг. Гэхдээ зөрчлийг багасгагч тогтолцоо нь өвчний суурь шалтгааныг нь олж илрүүлдэг. Гэвч энэ нь түрүүчийн зөрчилтөй байдлыг ухрааж байна гэсэн үг биш. Энэхүү ерөнхий нийлмэл нь үйлдэх хэрэгтэй гэсэн үед ямар ч ноцтой тохиолдолгүйгээр энгийн нөхцөл байдлыг цомхотгох замаар эрүүл бус нөхцөл байдлыг цомхотгодог. Энэ ерөнхий нийлмэл нь бүх л харилцаанд алдагдал болдог. Энгийн таамгуудын нийлбэр нь туршигч этгээдийн хувьд ажлын зэвсэг, гэвч онолч энэхүү таамгуудад бодит байдлын эцсийн дүр зургийг харах шаардлагагүй байдаг. Иймээс л энэхүү таамгаас эмч болоод өвчтөний мистик нэгдлийг бий болгох шаардлагагүй байгаа юм. Энэ мистик нэгдлийг эмч болоод өвчтөн тус тусдаа өөрөөр мэдэрч хүлээн авдаг ба эмчилгээг зөвхөн ид шид, домын үйлд уусган алга болгодог юм.

Ямар ч байсан сэтгэл задлан шинжлэл нь эмчлэгч, өвчтөн, нийгмийн бүлэг, хэнд нь ч ойлгомжгүй байгаа үзэгдлийг нийгмээр хүлээн зөвшөөрөгдсөн хэлээр илэрхийлэхэд оршино гэсэн тодорхойлолтоор хязгаарлаад энэ өгүүллэгээ дуусгая.